



МОНГОЛ УЛСЫН  
УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ЯАМНЫ  
ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГЫН  
ТУШААЛ

2023 оны 04 сарын 04 өдөр

Дугаар А/36

Улаанбаатар хот

Сарын аян зохион байгуулах тухай

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1.4 дэх заалт, 23 дугаар зүйлийн 23.1 дэх хэсэг, Уул уурхай, хүнд үйлдвэрийн салбарын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн салбар хорооны ажиллах журмын 2.1, 3.1.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн дэлхийн өдрийг угтан Уул уурхай, хүнд үйлдвэрийн салбарын “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сарын аян”-ыг зохион байгуулах ажлын удирдамжийг хавсралт ёсоор баталсугай.

2. Удирдамжийн дагуу аюулгүй ажиллагаа, ажлын байрны нөхцөлийг сайжруулах чиглэлээр зохион байгуулах ажлын төлөвлөгөө батлан, хэрэгжилтийг ханган ажиллахыг геологи, уул уурхай, хүнд үйлдвэр, газрын тосны салбарын нийт аж ахуйн нэгж, ажил олгогчдод үүрэг болгосугай.

3. Тушаал, удирдамжийг салбарын нийт аж ахуйн нэгж, байгууллагуудад хүргүүлэн сарын аяны хүрээнд зохион байгуулсан ажлын талаарх тайлан, мэдээллийг нэгтгэн 2023 оны 05 дугаар сарын 22-ны өдрийн дотор салбар хороонд ирүүлэхийг Ашигт малтмал, газрын тосны газар /Л.Баярмандал/-т үүрэг болгосугай.

ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН  
ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН  
ГҮЙЦЭТГЭГЧ



Б.БЯМБАДАГВА

1508 01 0172

Төрийн нарийн бичгийн даргын  
2023 оны 04 дүгээр сарын 04-ны өдрийн  
дугаар тушаалын хавсралт

А/36.

**Уул уурхай, хүнд үйлдвэрийн салбарын  
“Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сарын аян”-ыг  
зохион байгуулах ажлын удирдамж**

**Нэг. Зорилго:**

Геологи, уул уурхай, газрын тос, хүнд үйлдвэрийн салбарын хэмжээнд хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хууль тогтоомж, дүрэм, журам, стандартын хэрэгжилтийг сайжруулах, салбарт ажиллагсдын эрүүл, аюулгүй орчинд ажиллаж, амьдрах нөхцөлийг бүрдүүлэх, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчнөөс урьдчилан сэргийлэхтэй холбоотой үйл ажиллагааг эрчимжүүлэхэд оршино.

**Хоёр. Хамрах хүрээ**

Геологи, уул уурхай, газрын тос, хүнд үйлдвэрийн салбарт үйл ажиллагаа явуулж буй нийт аж ахуйн нэгжүүд, ажил олгогчид, ажилтан ажиллагсад.

**Гурав. Хугацаа:**

Сарын аян 2023 оны 4-р сарын 10-ны өдрөөс 5-р сарын 10-ны өдрийг хүртэл 1 сарын хугацаанд үргэлжилнэ.

**Дөрөв. Аяны хүрээнд авч хэрэгжүүлэх арга хэмжээ**

1. Ажил олгогч, аж ахуйн нэгжүүд нь Олон Улсын хөдөлмөрийн байгууллагаас гаргасан “Эрүүл, аюулгүй ажил-Бидний суурь эрх” уриан дор сарын аяныг зохион байгуулах удирдлагын шийдвэр гаргаж, холбогдох зардлыг төсөвлөх,
2. Сарын аяны хүрээнд ажилчдын эрүүл мэнд, ажлын байрны нөхцөлийг сайжруулах, аюулгүй ажиллагааны удирдлага зохион байгуулалтыг боловсронгуй болгох чиглэлээр үр дүнтэй, хэмжихүйц арга хэмжээний төлөвлөгөө баталж хэрэгжүүлэн, дүгнэх.
3. Аянд удирдлагын манлайлалыг хангаж, ажилтан бүрийг оролцуулан, мэдлэг хандлага, соёлыг төлөвшүүлэх.

**Тав. Аяныг дүгнэх, үр дүнг тооцох**

4. Аяны үр дүнг дотооддоо үнэлж, дүгнэн, идэвхитэй, үр бүтээлтэй оролцсон бүтэц, нэгж, ажилтныг урамшуулах.
5. Аяны хүрээнд зохион байгуулсан ажлын тайланг фото зураг, видео бичлэг, бусад хэлбэрээр баталгаажуулах.
6. Үр дүнгийн тайланг УУХҮЯ-ны ХАБЭА-н салбар хороонд ирүүлэх

Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам